

ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ХОЛБООТОЙ НАРИЙВЧИЛСАН ЖУРАМД ӨГӨХ САНАЛ, ШҮҮМЖ

Танилцуулга

Нээлттэй Нийгэм Форум, Төлсөн авсанаа нийтэл (ТАН) иргэний нийгмийн эвслээс Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамтай хамтран Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 ба 62.3.4 дүгээр зүйлийн хэрэгжилтийг хангах зорилгоор газрын тосны үйл ажиллагаанд холбогдох дүрэм, журмуудын төслийг иргэний нийгмийн байгууллагуудад танилцуулж санал, шүүмж авах хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Хэлэлцүүлгийн явцад “Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журам”-ын төслийг сайжруулахтай холбоотой иргэний нийгмийн байгууллагуудаас гаргасан санал шүүмжийг “Хуулийн шүүмж”-ийн энэ дугаарт хэвлэн нийтлэв.

Ерөнхий санал, шүүмж

Газрын тосны үйлдвэрлэлийн тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа нь Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлд заасан захиргааны акт болно.¹ Ийнхүү захиргааны акт болохын хувьд тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд Захиргааны ерөнхий хуулийн Гуравдугаар бүлэгт заасан Захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд баримтлах нийтлэг журмыг дагаж мөрдөх учиртай. Ялангуяа газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь байгаль орчинд сөрөг нөлөө бүхий үйл ажиллагаа болохын хувьд орон нутгийн иргэд, оршин суугчдын эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөх нөхцөл байдал үүсэх магадлал өндөр юм. Иймээс тусгай зөвшөөрөл олгоход Захиргааны ерөнхий хуулийн 26 ба 27 дугаар зүйлд заасан Сонсох ажиллагааг зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай юм.

Иймд журмын төслийг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх замаар тухайн шийдвэрийн улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх талууд болох газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэр байрших орон нутгийн иргэдийн оролцоог хангах боломжийг бүрдүүлэх нь зүйтэй.

Хуульд заасан нууцад хамаарахаас бусад үйл ажиллагаанд ил тод, нээлттэй байх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим юм.² Иймд журмын төсөлд тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд ил тод байдлыг хангахад чиглэсэн тодорхой заалтыг тусгах замаар Захиргааны ерөнхий хуульд нийцүүлж, тусгай зөвшөөрлийн мэдээллийн ил тод байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх нь зүйтэй.

Журмын төслийн 3.2-т тусгай зөвшөөрлийн өргөдөлд Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний (БОНБНУ) тайланг хавсаргахаар тусгасныг сайшаан дэмжихийн хамт тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахад мөн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд нэмэлт тодотгол хийж, тайланг хавсаргах заалтыг тусгах саналтай байна.

1 Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 “Захиргааны акт гэж захиргааны байгууллагаас тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар нийтийн эрх зүйн хүрээнд гадагш чиглэсэн, эрх зүйн шууд үр дагавар бий болгосон амаар, бичгээр гаргасан захирамжилсан шийдвэр болон үйл ажиллагааг ойлгоно.

2 Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг

Тусгай санал, шүүмж

Зүйл заалтын дугаар	Санал, шүүмж	Тайлбар үндэслэл
1.2	“Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль” гэсний дараа “Захиргааны ерөнхий хууль” гэж нэмэх	Уг журмаар зохицуулах харилцаанд зайлшгүй дагаж мөрдөх шаардлагатай хууль тогтоомжийг хамаарах хууль тогтоомж болгон тусгах
1.2	“Байгаль орчныг хамгаалах тухай хууль” гэсний дараа “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль” гэж нэмэх	
3.2.3	“эрх бүхий аж ахуйн нэгжээр хийлгэсэн” гэснийг “эрх бүхий байгууллагын баталсан” гэж өөрчлөх	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дагуу БОНБНУ-ий тайланг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батласнаар хүчин төгөлдөр болдог билээ. Иймд эрх бүхий байгууллагаас батлагдсан нарийвчилсан үнэлгээний тайланг хавсаргах нь зүйтэй.
4 зүйл	“Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Сонсох ажиллагааг Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу явуулна” гэсэн заалт нэмэх	Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх
4 зүйл	“Төрийн захиргааны төв байгууллага тусгай зөвшөөрөл олгосноос хойш ажлын 7 өдөрт багтаан тухайн тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбай байрших аймаг, сум, дүүргийн Засаг даргад мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтэлнэ” гэсэн заалт нэмэх	Тусгай зөвшөөрлийн мэдээллийн ил тод байдлыг хангах
5 зүйл	“Төрийн захиргааны төв байгууллага тусгай зөвшөөрлийг сунгаснаас хойш ажлын 7 өдөрт багтаан тухайн тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбай байрших аймаг, сум, дүүргийн Засаг даргад мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтэлнэ” гэсэн заалт нэмэх	
5.2.8	“Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан /нэмэлт тодотгол хийсэн байх/” гэсэн заалт нэмэх	Журмын төслийн 2.5.7-д тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулах хүсэлт гаргахад нэмэлт тодотгол хийсэн Техник, эдийн засгийн үндэслэлийг хавсаргах шаардлагыг тусгажээ. Тэгвэл төслийн Техник эдийн засгийн үндэслэлд нэмэлт тодотгол хийгдсэн тохиолдолд түүнд үндэслэн боловсруулагддаг Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд мөн нэмэлт тодотгол хийгдэх учиртай.
7.1.1	“Тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэсний дараа “Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж” гэж нэмэх	Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 12 дугаар зүйлд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нийтлэг болон бусад үүргийг хуульчилжээ. Дээрх үүргийг зөрчсөн явдал нь тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэл болох учиртай.
10.1	“төв байгууллага” гэсний өмнө “төрийн захиргааны” гэж нэмэх	Хэллэг найруулгыг сайжруулах

Дугаарыг эрхэлсэн: Д.ЭРДЭНЭЧИМЭГ

ННФ-ын Эдийн засгийн хөтөлбөрийн менежер

Хаяг: Жамъян гүний гудамж - 5/1
Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар - 14240
Монгол Улс

Утас: 976-11-313207
Факс: 976-11-324857
Вэб: www.forum.mn
И-мэйл: osf@forum.mn

